

ТӨСӨЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Ерөнхий зүйл

Уг төслөөр олгох Худалдаа бизнесийн 13.34 га, Үйлчилгээ, амралтын 8.22 га, Үйлдвэрийн 18.75 га, Агуулах, логистикийн 23.31 га газрыг орчин үеийн стандарт шаардлага хангасан барилга байгууламж барих, байгаль орчинд хоргүй үйл ажиллагаа эрхлэх, ногоон байгууламж зам талбай барьж байгуулах.

1. Гүйцэтгэх ажлын цар хүрээ, хугацаа:

1.1 “Замын-Үүд” чөлөөт бүс

1.2 Газар эзэмших, ашиглах хугацаа 5-60 жил

1.3 Төсөл сонгон шалгаруулалтанд оролцогч нь газар эзэмших, ашиглах гэрээнд гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хуанлийн 90 хоногт багтаан барилгын ажлыг гүйцэтгэж эхлэх;

2. Төсөл сонгон шалгаруулалтанд оролцогчийн шаардлага:

2.1. Хөрөнгийн баталгаа, төлбөрийн чадвартай байх.

2.2. Оролцогч нь хөрөнгийн баталгаа, төлбөрийн чадвар болон төсөл шалгаруулалтанд ирүүлсэн мэдээллийн үнэн зөвийг бүрэн хариуцна.

2.3. Мэргэжлийн боловсон хүчний болон техник, тоног төхөөрөмж, технологийн чадавх, нөөцтэй байх.

2.4. Оролцогч нь өөрийн байгууллагын үндсэн мэдээллээ хавсралт төслийн маягтын дагуу бөглөж ирүүлнэ.

2.5. Оролцогч нь төслийн шаардлага болон “Чөлөөт бүсийн тухай хууль” болон бусад эрх зүйн актуудыг нэг бүрчлэн судалж, төслийг зохих шаардлагын дагуу боловсруулан “Замын-Үүд” чөлөөт бүсийн Захирагчийн Ажлын албанд дор дурдсан хугацаанд багтаан ирүүлнэ.

2.6. Оролцогч нь төсөл сонгон шалгаруулалтын талаар тодруулах буюу нэмэлт мэдээлэл авах шаардлагатай бол тухайн зард заасан хаяг болон холбогдох дугаараар хандаж болно.

2.7. Оролцогч нь Төрийн сангийн /100900036011/ дансанд 12500 /арван хоёр мянга таван зуун төгрөг/ төлсөн байх.

3. Төслийн бүрдэл:

Төсөл нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:

3.1. Аж ахуйн нэгжийн бүртгэлийн гэрчилгээний баталгаажсан хуулбар

3.2. Төслийн маягт

3.3. Төслийг “Төслийн удирдлагын арга зүйн заавар” MNS ISO 21500 стандартын дагуу боловсруулах

3.4. Төсөл сонгон шалгаруулалтаар эзэмших, ашиглах газарт барих барилга байгууламжийн архитектур төлөвлөлтийн эх загвар /эскиз/ зураг

3.5. Барилга байгууламжийн инженерийн хангамжийн ерөнхий шийдлийг тодорхойлсон байх

3.6. Тухайн үйчилгээ нь байгаль орчин болон хүн амын эрүүл мэнд, аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөхгүй байх

3.7. Мөн чөлөөт бүс болон хот, суурин газрын нийгэм, эдийн засгийн хөгжилд нөлөөлөх ач холбогдол, үр ашгийн талаарх тооцоолол

4. Төслийн саналыг бэлтгэх ба баталгаажуулалт:

4.1. Төслийн саналыг давхар дугтуйнд хийж тамгалж ирүүлнэ.

4.2. Оролцогч 4-р зүйлд заасан иж бүрдэл бүхий төслийн эх хувь болон хуулбар хувийг “ЭХ ХУВЬ, ХУУЛБАР ХУВЬ” гэсэн бичиглэл бүхий дугтуйнд хийж битүүмжлэн, тэдгээрийг дахин давхар нэг дугтуйнд хийж ирүүлнэ.

4.3. Гадна дугтуйн дээр “Замын-Үүд” чөлөөт бүсийн Захирагчийн Ажлын албанд гэж хаяглан, 2017 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн 12.00 цагаас “ӨМНӨ НЭЭЖ ҮЛ БОЛНО” гэж тэмдэглэсэн байна.

4.4. Доторх дугтуйн дээр санал ирүүлж буй байгууллагын нэр хаяг байна.

4.5. Хэрэв саналыг заасны дагуу дугтуйлж ирүүлээгүй тохиолдолд “Замын-Үүд” чөлөөт бүсийн Захирагчийн ажлын алба нь хариуцлага хүлээхгүй болно.

4.6. Зар мэдээнд заасан хугацаанаас хоцролгүй “Замын-Үүд” чөлөөт бүсийн Захирагчийн Ажлын албанд ирүүлнэ.

4.7. Оролцогч ирүүлсэн төслөө хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө бичгээр мэдэгдэл өгч өөрийн төслийг буцаан авч болно.

“ЗАМЫН-ҮҮД” ЧӨЛӨӨТ БҮСИЙН ЗАХИРАГЧИЙН

АЖЛЫН АЛБА